

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Могойн гол ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, зорилтот түвшиний гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/22/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 261628 Цахим хаяг: tegshee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн

Захирал, ахлах аудитор: Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: ikhermurun.audit@gmail.com

Чанарын хяналтын менежер: Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.1 Байгууллагын үйл ажилагаа	9
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10-12
4. Аудитын тайлан	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Дотоод хяналт	13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
4.4 Материаллаг байдал.....	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
8. Аудитын илрүүлэлт.....	16
8.1 Залруулсан алдаа	16
8.2 Төлбөрийн акт	16
8.3 Албан шаардлага	16
8.4 Зөвлөмж.....	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.16 № 01/261
танай _____-ны № _____-т

“МОГОЙН ГОЛ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН АЖЛЫГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ О.УУГАНБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Могойн гол” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Могойн гол” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд “Могойн гол” ХК нь Хөвсгөл, Завхан аймгийн 60 гаруй байгууллага, аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, 100.0 мянган тонн нүүрсний 4,743.1 сая төгрөгийн борлуулалт хийж, 3,962.2 сая төгрөгийн зардал гарган 780.9 сая төгрөгийн үр ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд бусад хуулийн нийцэлтэй холбоотой асуудлыг авч үзээгүй боловч “Могойн гол” ХК-ийн ерөнхий инженер, Гүйцэтгэх захирлын ажлыг хавсран давхар гүйцэтгэж байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.” гэсэн заалттай нийцэхгүй

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Могойн гол” ХК нь 2021 оны зорилтот түвшний биелэлт 1,000.0 м.куб хөрс хуулалтын ажил хийж 115.0 мянган тонн нүүрс борлуулах зорилт тавьж 810.2 мянган м.куб хөрс хуулалтын ажил хийж 100.0 мянган тонн нүүрс борлуулж 87.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 16 өдөр

№ 27/А2260434/ХӨА-2022/
22/АА-СИА-ОРА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн "Могойн гол" ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын хэрэгжилтийг шалгахад уурхайчдын баярын хүлээн авалтын зардалд 2,032,666 /Хоёр сая гучин хоёр мянга зургаан зуун жаран зургаа/ төгрөг, шагнал, өргөмжлөлд 2,823,122 /Хоёр сая найман зуун хорин гурван мянга нэг зуун хорин хоёр / төгрөг, зочин төлөөлөгч хүлээн авахад 2,478,320 /Хоёр сая дөрвөн зуун далан найман мянга гурван зуун хорь/ төгрөг, нийт 7,334,108 /Долоон сая гурван зуун гучин дөрвөн мянга нэг зуун найм / төгрөгийг зарцуулж тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Энэ нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.3 /төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;/ гэж заасныг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх, үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын тогтоолоор өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газар¹т ирүүлэх,
2. Цаашид Засгийн газрын тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг "Могойн гол" ХК-ийн гүйцэтгэх захирлын ажлыг хавсран гүйцэтгэгч О.Ууганбаяр, нягтлан бодогч Л.Шинэцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

"ИХЭРМӨРӨН-АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ  Б.МЯДАГМАА

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 16 өдөр

№ 30/А2260434/2022-2022/
22/АА-СИ.А-0121

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн "Могойн гол" ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Могойн гол" ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтад заасны дагуу өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, мөрдөх" зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газар¹т ирүүлэх,
2. Цаашид Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг "Могойн гол" ХК-ийн гүйцэтгэх захирлын ажлыг хавсран гүйцэтгэгч О.Ууганбаяр, нягтлан бодогч Л.Шинэцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

"ИХЭРМӨРӨН-АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ  Б.МЯДАГМАА

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

1.Аудитын санал дүгнэлт

МОГОЙН ГОЛ ХК-ИЙН ЗАХИРЛЫН АЖЛЫГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ О.УУГАНБАЯР ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Могойн гол ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Могойн гол ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Могойн гол ХК нь Хөвсгөл, Завхан аймгийн 60 гаруй байгууллага аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж 100.0 мян.тн нүүрсний 4,743.1 сая төгрөгийн борлуулалт хийж, 3,962.2 сая төгрөгийн зардал гарган 780.9 сая төгрөгийн үр ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд бусад хуулийн нийцэлтэй холбоотой асуудлуудыг авч үзээгүй боловч Могойн гол ХК-ийн гүйцэтгэх захирлын ажлыг, ерөнхий инженер хавсран давхар гүйцэтгэж байгаа нь НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 18.1 "Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно" заалттай нийцэхгүй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Могойн гол ХК нь 2021 онд 1,000.0 мян.м3 хөрс хуулалтын ажил хийж, 115.0 мян.тн нүүрс борлуулах зорилт тавьж 810.2 мян.м3 хөрс хуулалтын ажил хийж, 100.0 мян.тн нүүрс борлуулж 87.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	146,272,287.03	1,033,161,273.91
1.1.2	Дансны авлага	290,640,137.70	143,156,855.18
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	13,269,989.37	5,244,932.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	3,769,174,445.62	3,833,831,706.66
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	96,100,000.00	76,419,820.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	24,766,738.63	27,055,760.27
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,340,223,598.35	5,118,870,348.02
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,742,201,970.37	1,437,360,234.91
1.2.2	Биет бус хөрөнгө	125,466,800.00	157,866,800.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,867,668,770.37	1,595,227,034.91
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,207,892,368.72	6,714,097,382.93
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	262,740,965.55	60,834,622.42
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	337,835,466.54	405,878,014.05
2.1.1.4	НДШ - ийн өглөг	55,919,380.68	
2.1.1.5	Богино хугацаат зээл	336,257,187.41	
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	480,000,000.00	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	134,582,876.75	886,375,948.25
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	19,909,720.64	2,123,231.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,627,245,597.57	1,355,211,815.72
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	795,876,840.80	793,230,990.80
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	795,876,840.80	793,230,990.80

2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,423,122,438.37	2,148,442,806.52
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	42,310,722.00	42,310,722.00
2.3.2	хувийн	40,651,478.00	40,651,478.00
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,375,789,181.23	1,375,789,181.23
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	202,833,326.81	202,833,326.81
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,123,185,222.31	2,904,069,868.37
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,784,769,930.35	4,565,654,576.41
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,207,892,368.72	6,714,097,382.93

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,531,804,476.58	4,690,505,700.94
2	Борлуулалтын өртөг	2,119,004,198.90	3,135,861,347.52
3	Нийт ашиг(алдагдал)	412,800,277.68	1,554,644,353.42
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	45,261,775.31	52,595,974.89
9	Борлуулалт, маркетингийн зардал		276,479,335.55
10	Ерөнхий ба удирдлагын зардал	283,207,341.62	324,070,833.81
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	67,265,742.15	127,648,653.88
13	Гадаад валютын ханшийн зөрүүнийолз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	107,588,969.32	879,041,505.07
19	Орлогын татварын зардал	10,758,896.93	98,156,859.01
20	Татварын дараах ашиг (алдагдал)	96,830,072.39	780,884,646.06
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	96,830,072.39	780,884,646.06
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютынхөрвүүлэлтийн зөрүү		
	Бусадолз (гарз)		
24	Орлогын нийт дүн	96,830,072.39	780,884,646.06
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	/төгрөгөөр/	
				Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	82,962,200.00	816,691,685.80	202,833,326.81	2,029,339,243.20	3,131,826,455.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-2,984,093.28	
Залруулсан үлдэгдэл	82,962,200.00	816,691,685.80	202,833,326.81	2,026,355,149.92	3,131,826,455.81
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				96,830,072.39	123,686,911.93
Өмчид гарсан өөрчлөлт					
Дахин үнэлгээний нэмэгдэл		559,097,495.43			559,097,495.43
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	82,962,200.00	1,375,789,181.23	202,833,326.81	2,123,185,222.31	3,784,769,930.35
Залруулсан үлдэгдэл	82,962,200.00	1,375,789,181.23	202,833,326.81	2,123,185,222.31	3,784,769,930.35
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				780,884,646.06	780,884,646.06
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	82,962,200.00	1,375,789,181.23	202,833,326.81	2,904,069,868.37	4,565,654,576.41

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,854,020,128.55	6,193,871,227.82
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,786,981,851.00	6,026,683,115.82
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	67,038,277.55	167,188,112.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,091,558,279.40	4,444,675,153.53
	Ажиллагчдад төлсөн	729,520,635.20	869,785,924.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	163,930,267.00	317,241,937.27
	Бараа материал худалданавахад төлсөн	745,298,966.00	912,766,999.00
	Ашиглалтын зардалд төлсөн	96,999,379.64	119,322,988.05
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	765,029,130.00	1,450,198,266.40
	Хүүний төлбөрт төлсөн		11,736,711.50
	Татварын байгууллагад төлсөн	294,762,820.87	664,518,291.76
	Даатгалын төлбөрт төлсөн	80,431,175.00	4,581,675.00
	Бусад мөнгөн зарлага	215,585,905.69	94,522,360.55
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(237,538,150.85)	1,749,196,074.29
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		46,049,900.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		46,049,900.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		46,049,900.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	500,000,000.00	
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	500,000,000.00	
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	196,786,027.40	816,257,187.41
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	186,786,027.40	336,257,187.41
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг	10,000,000.00	480,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	303,213,972.60	816,257,187.41
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	65,675,821.75	886,888,986.88
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	80,596,465.28	146,272,287.03
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	146,272,287.03	1,033,161,273.91

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
5	Нийт орлогын дүн	мян.төг	2,577,066.10	5,179,750.0	4,743,101.7	436,648.3	91.6
1	Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	2,531,804.40	5,111,750.0	4,671,258.1	440,491.9	91.4
2	Туслах үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	0.00	30,000.0	32,702.3	(2,702.3)	109.0
3	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	0.00	0.00	0.00	0.00	
4	Халаалтын орлого	мян.төг	45,261.70	38,000.0	39,141.3	(1,141.3)	103.0
6	Нийт зардал	мян.төг	2,469,477.20	4,778,339.0	3,864,060.1	914,278.9	80.9
7	Нүүрсний борлуулалтын өртөг	мян.төг	1,847,421.00	3,793,406.6	3,033,492.2	759,914.4	80.0
8	Борлуулалтын зардал	мян.төг	169,095.00	146,681.4	276,479.3	(129,797.9)	188.5
9	Удирдлагын зардал	мян.төг	283,207.30	444,022.7	324,070.8	119,951.9	73.0
10	Туслах үйл ажиллагааны зардал	мян.төг	27,654.90	36,500.00	26,592.0	9,908.0	72.9
11	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	67,265.60	274,217.8	127,648.7	146,569.1	46.6
12	Уурын зуухны зардал	мян.төг	74,833.40	83,510.5	75,777.1	7,733.4	90.7
13	Нийт ашиг	мян.төг	107,588.90	401,411.0	879,041.6	(477,630.6)	219.0
14	Хөрс хуулалт	мян. м куб	1,040.50	1,000.0	810.2	189.8	81.0
15	Олборлох нүүрсний хэмжээ	мян.тн	75.00	100.00	90.0	10.0	90.0
16	Борлуулах нүүрсний хэмжээ	мян.тн	62.80	115.00	100.0	15.0	87.0

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Могойн гол ХК-ийн зорилго нь үйл ажиллагаандаа орчин үеийн дэвшилт технологийг нэвтрүүлэн олон улсын чанар стандартад нийцүүлсэн нүүрсийг олборлож, ажилтнуудаа аюулгүй орчинд, сэтгэл хангуулан ажиллаж, өсөж дэвших боломжоо ханган ажиллаж, эдийн засгийн хувьд бие даасан орон нутгийн хөгжлийг тэргүүлэгч компани болоход оршино. Могойн гол ХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсад ашигт малтмалын хайгуул, олборлолт хийх болон хэрэв боломжтой гэж үзвэл боловсруулах
- Ашигт малтмалыг боловсруулах, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдах худалдан авах импортлох, экспортлох зэргээр гадаад дотоод худалдаа эрхлэх
- Монгол улсын хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 51 хувийг Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, 49 хувийг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Могойн гол ХК нь 1970 онд Могойн голын уурхай нэрээр анх үүсгэн байгуулагдаж байсан бөгөөд Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1994 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 35 дугаар тогтоолоор хувьцаат компани болгон өөрчилсөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалттай нийцэж байна.

Могойн гол ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 0.8 сая төгрөгөөр тогтоосон нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1.13-д “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна. Могойн гол ХК нь 2014 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн А/20 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж

байгаа тул холбогдох стандарт, хууль тогтоомжийн шинэчлэлтэй нийцүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	146,272.3	1,033,161.3	886,889.0
Авлага	303,910.1	148,401.8	(155,508.3)
Урьдчилж төлсөн тооцоо	96,100.0	76,419.8	(19,680.2)
Бараа материал	3,769,174.4	3,833,831.7	64,657.30
Бусад эргэлтийн хөрөнгө	24,766.7	27,055.8	2,289.1
Үндсэн хөрөнгө	1,742,202.0	1,437,360.2	(304,841.8)
Биет бус хөрөнгө	125,466.8	157,866.8	32,400.0
Нийт хөрөнгийн дүн	6,207,892.3	6,714,097.4	506,205.1
Өр төлбөрийн дүн	2,423,122.4	2,148,987.2	(274,135.2)
Богино хугацаат өглөг	1,627,245.6	1,355,756.2	(271,489.4)
Урт хугацаат өглөг	795,876.8	793,231.0	(2,645.8)
Эздийн өмч	3,784,769.9	4,565,654.6	780,884.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,207,892.3	6,714,097.4	506,205.1

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 0.2 сая төгрөг, банк дахь мөнгөний үлдэгдэлд Төрийн банк, Хаан банкны харилцах дансанд байгаа 1,033.2 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 148.4 сая төгрөг байгаагаас 91.4 хувийг борлуулалтын авлага эзэлж байна.

Тайлант онд урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 76.4 сая төгрөг байгаа нь 2021 онд байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажлын төлбөрт 6.4 сая төгрөг шилжүүлсэн, 2020 онд Гранд Майнинг Экюпмент ХХК-тай уурхайн өрмийн машин 852.0 сая төгрөгөөр худалдан авахаар гэрээ байгуулж урьдчилгаа 70.0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч Могойн гол ХК-ийн санхүүгийн хүндрэлээс шалтгаалж үлдэгдэл төлбөрөө бүрэн шилжүүлээгүй, гэрээний биелэлт хангагдаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,839.3 сая төгрөг болж 70.1 сая төгрөгөөр өссөн нь дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 712.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,437.4 сая төгрөг болж 304.8 сая төгрөгөөр буурсан байна. Өөрийн хөрөнгөөр тэсрэх материалын харуулын байр, тэсрэх материалын агуулах, уурхайн карьерын хашаа нийт 38.6 сая төгрөгийн барилга байгууламж, машин тоног төхөөрөмж дансанд уурхайн машин механизм 108.0 сая төгрөгөөр капиталжуулсан, 2.2 сая төгрөгийн мотоцикл, 35.7 сая төгрөгийн бусад тоног төхөөрөмжөөр нэмэгдсэн байна.

Хувьцаа Эзэмшигчдийн хурлын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 05 дугаар тогтоолоор үлдэх өртөггүй, ашиглалтын хугацаа дууссан 31.7 сая төгрөгийн 2 ширхэг хөрс тээврийн автомашин, 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн өмч хамгаалах комиссын шийдвэрээр 2.7 сая төгрөгийн тавилга эд хогшил, 2.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж акталж данснаас хассан байна. Тайлант хугацаанд хуримтлагдсан элэгдэл дансанд 842.6 сая төгрөгийн өөрчлөлт гарсан байна.

Биет бус хөрөнгө дансанд 2020-2025 оны ашигт малтмалын ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэл /ГЭЗҮ/-ийг Датаресурс ХХК-аар гүйцэтгүүлэхээр 2020 онд гэрээ байгуулж урьдчилгаа 26.1 сая төгрөг шилжүүлсэн бөгөөд 2021 онд гүйцэтгэлээр хүлээн авч 36.0 сая төгрөгөөр үнэлж данс бүртгэлд тусгасан байна.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2001 онд ажилчдын халуун усны барилга барьж эхэлсэн боловч цэвдэгтэй газар таарч барилгыг цааш үргэлжлүүлэх боломжгүй болсон байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 1,355.2 сая төгрөгийн өр төлбөр байгаа нь урьдчилж орсон орлого 886.4 сая төгрөг, татварын өглөг 405.9 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчид өглөг 62.5 сая төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 1978 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Засгийн газарт буцаан төлөх гэрээгээр олгосон зээлийн үлдэгдэл 344.2 сая төгрөг, 2001 онд Япон улсын хөрөнгө оруулалтаар 5-н жилийн хугацаатай хүүгүй олгогдсон 449.0 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр байна.

Могойн гол ХК нь 2020 онд ХААН банкнаас 1 жилийн хугацаатай 500.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зориулалттай зээл авч үйл ажиллагаандаа зарцуулсан ба 2021 онд зээлийн эргэн төлөлтийн үлдэгдэл 336.3 сая төгрөгийг бүрэн төлж дууссан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл төрийн өмч 42.3 сая төгрөг, хувьцаа эзэмшигчдийн өмч 40.7 сая төгрөг байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зориулалтаар үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалтын үйл ажиллагааны зардал, удирдлагын зардал, туслах үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Нийт зардал өмнөх онтой харьцуулахад 1,394.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулалт нэмэгдэж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг өссөнөөс шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт тэсрэх материал, түлш шатахуун, цалин, НДШ, хөдөлмөр хамгаалал, сэлбэг хэрэгсэл, цахилгаан, элэгдэл, татвар хураамж, харуул хамгаалалтын зардлуудыг хамруулсан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Могойн гол ХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТУЗ-ийн 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Могойн гол ХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 5,179.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 4,693.4 сая төгрөгөөр, 486.4 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,447.7 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Хувьцаа Эзэмшигчдийн хурлын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолоор Могойн гол ХК-ийн 2021 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 84.9 сая төгрөгөөр тодотгож нийт зардал 4,778.3 сая төгрөг болсон байна.

Гүйцэтгэлээр 4,743.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,864.0 сая төгрөгийн зардал гарган, 879.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 4,743.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 436.7 сая төгрөг буюу 8.4 хувиар тасарсан нь Биконстар ХХК-тай байгуулсан 50.0 мян.тн коксожсон нүүрс нийлүүлэх гэрээний дагуу 2021 оны бизнес төлөвлөгөөнд тусгасан боловч Ковид-19 цар тахлын улмаас хил хаагдаж худалдан авагч тал бүтээгдэхүүнээ бүрэн татан авч чадахгүй байгаа зэрэг асуудлууд нүүрсний борлуулалтын хэмжээ буурахад нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 3,864.0 сая төгрөг буюу 81.9 хувийн гүйцэтгэлтэй төлөвлөснөөс 914.3 сая төгрөг хэмнэсэн байна. Энэ нь үйлдвэрлэлийн зардал 730.3 сая төгрөгөөр хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 780.9 сая төгрөг болж 178.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд 2018 оны ногдол ашгийн өглөг 480.0 сая төгрөгийг Төрийн сангийн Хө.Хувьцааны ногдол ашиг дансанд төвлөрүүлсэн байна. ТУЗ, Хувьцаа Эзэмшигчдийн хурлаас 2019, 2020 онуудад компанидаа хөрөнгө оруулалт хийж техник эдийн засгийн үзүүлэлт, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор ногдол ашиг хуваарилаагүй байна.

3.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Хувьцаа Эзэмшигчдийн төлөөлөл 3, орон нутгийн төлөөллийг хэрэгжүүлэгч 3, хараат бус 3, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2021 онд 6 удаа зохион байгуулж 18 асуудал хэлэлцэж, хөрөнгөтэй холбоотой 4, үйл ажиллагаатай холбоотой 14 шийдвэр гарган ажилласан байна.

2021 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 166.9 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 97.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшуулал, шимтгэлийн зардалд 87.3 сая төгрөг, томилолтын зардалд 4.3 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 0.7 сая төгрөг, тээвэр шатахуун 2.4 сая төгрөг, хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал 0.5 сая төгрөг, ТУЗ-ийн хурлын зардал 1.8 сая төгрөгийн зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Могойн гол ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын хэрэгжилт, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн албан шаардлага, анхан шатны баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-аудит ХХК-ийн захирал, ахлах аудитор Б.Мядагмаа, аудиторын туслах Ж.Уранчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Ц.Мөнхтуяа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар анхан шатанд, дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Могойн гол ХК нь 2021 оны санхүүгийн тайланг Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01/09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Могойн гол ХК-ийн дотоод хяналт шалгалтын нэгжийг 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн захирлын А/09 дугаар тушаалаар 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Тайланд онд 5 чиглэлээр 66 хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлийг тайлагнаж ажилласан байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Могойн гол ХК нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл” Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 3,858.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 77.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 61.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 9 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Могойн гол ХК нь тайлант онд нийт 15,863.7 сая төгрөгийн 467 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 100 хувь мэдээллийг ил тод байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад уурхайчдын баяр тэмдэглэх, зочин төлөөлөгч хүлээн авахад нийт 7.3 сая төгрөгийг зарцуулсан нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Татвартай холбоотой хууль тогтоомжийн хүрээнд шалгахад хувь хүнээс худалдан авсан 49 ажил гүйлгээ, бараа материалын 50.8 сая төгрөгийн анхан шатны баримт дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн е-баримтгүй байна.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгахад Могойн гол ХК-ийн ерөнхий инженер О.Ууганбаяр нь гүйцэтгэх захирлын ажлыг хавсран давхар гүйцэтгэж байгаа нь НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 18.1 “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Могойн гол ХК-ийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй бөгөөд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 41.2 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгснөөс 85.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	7	41,226.3	6	41,226.3	1	0	85.7
Нийт дүн	7	41,226.3	6	41,226.3	1	0	85.7

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 заалтад заасны дагуу өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, мөрдөх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Могойн гол ХК-ийн санхүүгийн тайланд дараагийн аудитаар авч үзэх дараах асуудал байна. Үүнд:

1. 2001-2009 онуудад үүссэн хугацаа хэтэрсэн 48.5 сая төгрөгийн найдваргүй авлага
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 651.8 сая төгрөгийн хөрөнгийг Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолоор Орон нутгийн хувь нийлүүлсэн эх үүсвэрийг нэмэгдүүлэх шийдвэрийн талаар авсан арга хэмжээний талаар
3. Дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байгаа 5.7 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2001 онд баригдсан ажилчдын халуун усны барилга зэрэг асуудлыг анхаарах.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 342.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 284.1 сая төгрөгийн алдааг залруулж, 7.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 50.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 284.1 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд борлуулалт, маркетингийн зардал 276.5 сая төгрөгийг борлуулалтын өртөгт тайлагнасан.
- Үндсэн хөрөнгийн тодруулгад 2.2 сая төгрөгийн мотоциклыг машин тоног төхөөрөмж дансанд бүртгэсэн.
- Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал дансанд аудитын төлбөр 5.4 сая төгрөгийг бүртгэж дуусаагүй үйлдвэрлэл дансанд үлдэгдлээр байгаа нь тайлант үеийн үр дүнг 0.5 сая төгрөгөөр буруу илэрхийлсэн байгаа нь НББОУС 1.15-р параграфтай нийцэхгүй *Үнэлгээ ба хуваарилалт* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

8.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

8.3 Албан шаардлага

1. Уурхайчдын баярын хүлээн авалтын зардалд 2.0 сая төгрөг, шагнал, өргөмжлөлд 2.8 сая төгрөг, зочин төлөөлөгч хүлээн авахад 2.5 сая төгрөг, нийт 7.3 сая төгрөгийг

зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3 / төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;/ заалттай нийцэхгүй *Нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Өмнөх оны аудитаар өгсөн “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2 заалтад заасны дагуу өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, мөрдөх” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.” заалттай нийцэхгүй *Нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хувь хүнээс худалдан авсан 49 ажил гүйлгээ, бараа материалын 50.8 сая төгрөгийн анхан шатны баримт дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн е-баримтгүй байгаа нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.4-т “доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” заалттай нийцэхгүй *Иж бүрэн байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлд ажил гүйлгээг бүртгэхдээ борлуулагч талаас олгосон дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн е-баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэх.

2. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Могойн гол ХК-ийн ерөнхий инженер О.Ууганбаяр нь гүйцэтгэх захирлын ажлыг хавсран давхар гүйцэтгэж байгаа нь НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 18.1 “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно” заалттай нийцэхгүй *Нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.1. Өгсөн зөвлөмж:

ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Могойн гол ХК	5	334.9	3	284.1			1	0	1	50.8
Дүн		5	334.9	3	284.1			1	0	1	50.8
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Могойн гол ХК	2	7.3					1	7.3	1	0
Дүн		2	7.3					1	7.3		
Нийт дүн		7	342.2	3	284.1			2	7.3	2	50.8

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР 720090001-9070605

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

Б.ТЭГШДЭЛГЭР Огноо:

Г.ЭРДЭНЭЧИМЭГ Огноо:

Ц.МӨНХТУЯА Огноо:

Б.МЯДАГМАА Огноо: